



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэс сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/03/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитор: Д.Пүүжмаа
Утас:99080797
Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББО УС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.24 № 1302/400
танай _____ -ны № _____ -т

ТЭС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.ДАШДЭЛГЭР-Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ажилтнуудад үр дүнгийн урамшууллыг 465.9 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон, 649.1 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг авлагаар бүртгэсэн, батлагдсан орон тооноос 1 хүн илүү ажиллуулан 3,244.4 мянган төгрөгийн цалин олгосон, ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд цалингийн сангаас 4,529.2 мянган төгрөгийн тэтгэмж олгосон, ЗДТГ-ын дарга, санхүүгийн албаны дарга нар 4,319.1 мянган төгрөгийн нууцын нэмэгдлийг зохих журмыг зөрчин авсан, өмнөх жилд 1650.0 мянган төгрөгөөр худалдан авсан санхүүгийн программыг ашиглаагүй зэрэг зөрчил нь (Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтууд, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.2 дахь заалт зэрэгтэй нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй) байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

013025444

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>43853401.36</u>	<u>40867662.59</u>
33	АВЛАГА	1844386.00	1658468.13
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1684226.00	1658468.13
335	Бусад авлага	160160.00	0.00
3351	Байгууллагаас авах авлага	160160.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	42009015.36	39209194.46
351	Түүхий эд материал	75000.00	0.00
35110	Тусгай зориулалттай материал	75000.00	0.00
354	Хангамжийн материал	39434015.36	38209194.46
35410	Бичиг хэргийн материал	3568350.00	2213000.00
35420	Аж ахуйн материал	5565850.00	5304960.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4524018.36	9401318.36
35440	Түлш, шатах тослох материал	1128800.00	383821.10
35450	Барилгын засварын материал	3085000.00	3085000.00
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал	21561997.00	17821095.00
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад	2500000.00	1000000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1589051483.72</u>	<u>1535785498.31</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1589051483.72	1535785498.31
391	Газар		
392	Биет хөрөнгө	1584001483.72	1531147998.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	1442409641.00	1442409641.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-102371967.33	-137079628.05
39203	Авто-тээврийн хэрэгсэл	146084800.00	146084800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-71878546.42	-78594173.02
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	112037234.90	122387234.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-71073731.91	-83390610.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10339908.00	10339908.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9536262.76	-9712512.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	215128958.00	216128958.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-88052549.76	-98339619.48
39217	Ном	914000.00	914000.00
393	Биет бус хөрөнгө	5050000.00	4637500.00
39301	Програм хангамж	2602000.00	2602000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-952000.00	-1364500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3400000.00	3400000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1632904885.08</u>	<u>1576653160.90</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>8454080.00</u>	<u>52498.13</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8454080.00	52498.13

Тэс сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

413	Өглөг	8454080.00	52498.13
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	8454080.00	52498.13
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1624450805.08</u>	<u>1576600662.77</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1624450805.08	1576600662.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	427331491.04	427331491.04
51101	Өмч: - төрийн	427331491.04	427331491.04
512	Хуримтлагдсан үр дүн	1017794664.51	969944522.20
51210	Өмнөх үеийн үр дүн	1022246692.09	1017794664.51
51220	Тайлант үеийн үр дүн	-4452027.58	-47850142.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1632904885.08</u>	<u>1576653160.90</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	407173964.35	406707280.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67638140.00	13550000.00
120	Нийтлэг татварын бус орлого	67638140.00	13550000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	67638140.00	13550000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	67638140.00	13550000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	339535824.35	393157280.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	19011500.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	19011500.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11872424.35	55717480.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11872424.35	55717480.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	308651900.00	337439800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	308651900.00	337439800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	411625991.93	454557422.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	411625991.93	434557422.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	408259019.98	432976484.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209572287.00	210208670.00
210101	Үндсэн цалин	209572287.00	210208670.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26674967.00	27161906.00
210201	Тэтгэврийн даатгал	18292083.00	18790600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2095718.00	2062576.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1676579.00	1771061.00
210204	Ажилгүйдлийн даатгал	419143.00	412514.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4191444.00	4125155.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44927815.00	46331100.64
210301	Гэрэл, цахилгаан	1367815.00	2571100.64
210302	Түлш, халаалт	43560000.00	43760000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25435779.64	28672968.99
210401	Бичиг хэрэг	3829150.00	5790750.00
210402	Тээвэр, шатахуун	16701708.24	17065188.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4104921.40	4056140.09
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800000.00	260890.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	1500000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1268700.00	1460600.00
210604	Урсгал засвар	1268700.00	1460600.00
2107	Томилолт, зочны зардал	4719000.00	5361506.00
210702	Дотоод албан томилолт	4719000.00	5361506.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10546201.00	32468295.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9285951.00	31184780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232100.00	232100.00
210803	Даатгалын үйлчилгээ	219250.00	469100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227700.00	174325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73800.00	50600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	353400.00	203400.00
210807	Газрын төлбөр	138300.00	138290.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15700.00	15700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85114270.34	81311437.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23434754.00	16392052.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25300.00	303400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61654216.34	64615985.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3366971.95	1580938.27
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3366971.95	1580938.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3366971.95	1580938.27
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	20000000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	20000000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-4452027.58</u>	<u>-47850142.31</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-4452027.58</u>	<u>-47850142.31</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН						
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан	Дахин үнэлгээний	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	427,331,491.04	179,324,649.53	1,022,246,692.09	0.00	1,628,902,832.66
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	427,331,491.04	179,324,649.53	1,022,246,692.09	0.00	1,628,902,832.66
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх	427,331,491.04	179,324,649.53	1,022,246,692.09	0.00	1,628,902,832.66
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	427,331,491.04	179,324,649.53	1,022,246,692.09	0.00	1,628,902,832.66
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	427,331,491.04	179,324,649.53	1,017,794,664.51	0.00	1,624,450,805.08
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	854,662,982.08	358,649,299.06	2,040,041,356.60	0.00	3,253,353,637.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	427,331,491.04	179,324,649.53	1,017,794,664.51	0.00	1,624,450,805.08
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх	1,281,994,473.12	537,973,948.59	3,057,836,021.11	0.00	4,877,804,442.82

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	339535824.35	393157280.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	339535824.35	393157280.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	19011500.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	19011500.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11872424.35	55717480.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11872424.35	55717480.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	308651900.00	337439800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	308651900.00	337439800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	337885824.35	373157280.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	337885824.35	373157280.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	334518852.40	371576341.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201139200.00	216516600.00
210101	Үндсэн цалин	195844800.00	211222200.00
210105	Гэрээт ажлын хөлс	5294400.00	5294400.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27153800.00	29229800.00
210201	Тэтгэврийн даатгал	19108200.00	20569100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2011400.00	2165100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1609100.00	1732100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	402300.00	433100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4022800.00	4330400.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44927815.00	46331100.64
210301	Гэрэл, цахилгаан	1367815.00	2571100.64
210302	Түлш, халаалт	43560000.00	43760000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23385456.40	23299540.09
210401	Бичиг хэрэг	4068900.00	4435400.00
210402	Тээвэр, шатахуун	15211635.00	14808000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4104921.40	4056140.09
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1255200.00	1966100.00
210604	Урсгал засвар	1255200.00	1966100.00
2107	Томилолт, зочны зардал	4719000.00	5361506.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	4719000.00	5361506.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14546201.00	32468295.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13285951.00	31184780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232100.00	232100.00
210803	Даатгалын үйлчилгээ	219250.00	469100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227700.00	174325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73800.00	50600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	353400.00	203400.00
210807	Газрын төлбөр	138300.00	138290.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15700.00	15700.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17392180.00	16403400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17366880.00	16100000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25300.00	303400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3366971.95	1580938.27
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3366971.95	1580938.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3366971.95	1580938.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1650000.00</u>	<u>20000000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>1650000.00</u>	<u>20000000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>1650000.00</u>	<u>20000000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	1650000.00	20000000.00
223001	Бусад хөрөнгө	0.00	20000000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1650000.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1650000.00</u>	<u>-20000000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	330897800.00	324329266.40	337439800.00	336591561.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	330897800.00	324329266.40	337439800.00	336591561.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330897800.00	324329266.40	337439800.00	336591561.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201139200.00	201139200.00	216516600.00	216516600.00
210101	Үндсэн цалин	201139200.00	195844800.00	211222200.00	211222200.00
210105	Гэрээг ажлын хөлс	0.00	5294400.00	5294400.00	5294400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27153000.00	27153800.00	29229800.00	29229800.00
210201	Тэтгэврийн даатгал	19108000.00	19108200.00	20569100.00	20569100.00
210202	ТЭГЭМЖИЙН даатгал	2011300.00	2011400.00	2165100.00	2165100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1608700.00	1609100.00	1732100.00	1732100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	402500.00	402300.00	433100.00	433100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4022500.00	4022800.00	4330400.00	4330400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46632500.00	44927815.00	46632500.00	46331100.64
210301	Гэрэл, цахилгаан	2872500.00	1367815.00	2872500.00	2571100.64
210302	Түлш, халаалт	43760000.00	43560000.00	43760000.00	43760000.00
210303	Цэвэр, бохир ус				
210304	Байрны түрээс				
2104	Хангамж, бараа материалын зардал	23364700.00	22831821.40	23364800.00	23299540.09
210401	Бичиг хэрэг	3918900.00	3918900.00	3919000.00	4435400.00
210402	Тээвэр, шатахуун	14808000.00	14808000.00	14808000.00	14808000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4637800.00	4104921.40	4637800.00	4056140.09
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1966100.00	1255200.00	1966100.00	1966100.00
210604	Урсгал засвар	1966100.00	1255200.00	1966100.00	1966100.00
2107	Томилолт, зочны зардал	4259700.00	4719000.00	5766500.00	5361506.00
210701	Гадаад албан томилолт				
210702	Дотоод албан томилолт	4259700.00	4719000.00	5766500.00	5361506.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5560100.00	4910250.00	2560100.00	2483515.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2400000.00	2000000.00	1200000.00	1200000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232100.00	232100.00	232100.00	232100.00
210803	Даатгалын үйлчилгээ	469100.00	219250.00	469100.00	469100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227700.00	227700.00	227700.00	174325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73800.00	73800.00	73800.00	50600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2003400.00	2003400.00	203400.00	203400.00
210807	Газрын төлбөр	138300.00	138300.00	138300.00	138290.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15700.00	15700.00	15700.00	15700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх				
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20822500.00	17392180.00	11403400.00	11403400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20518300.00	17366880.00	11100000.00	11100000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	304200.00	25300.00	303400.00	303400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	330897800.00	327663400.00	337439800.00	336591561.73
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	330897800.00	327663400.00	337439800.00	336591561.73
122005	Орон нутгийн төсвөөс	330897800.0	327663400.0	337439800.00	336591561.73

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	54984780.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	34984780.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	34984780.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	29984780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	29,984,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	5000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	20000000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	20000000.00
223001	Бусад хөрөнгө	-	20,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	54984780.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	54984780.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	54,984,780.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тэс сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Д.Пүүжмаа ахлах аудитор Б.Дагвасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хэрэгжүүлсэн.

Тэс сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 3/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тэс сумын ЗДТГ нь иргэдээ сонсож, тэдний эрх ашгийг дээдлэн, төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд иргэн бүрд ил тод хөнгөн шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэж ажиллах гэсэн зорилгыг тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 454,557.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,818.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын (75 хувиар) буюу 5,113.7 мянга төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,844.3	1,658.4	185.9
Бараа материал	42,009.0	39,209.2	-2,799.8
Үндсэн хөрөнгө	1,589,051.5	1,535,785.5	-53,265.9
Нийт хөрөнгө	1,632,904.8	1,576,653.2	-56,251.7
Өр төлбөр	8,454.1	52.5	8,401.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,632,904.8	1,576,653.2	-56,251.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,632,904.8	1,576,653.2	-56,251.7

Авлага дансны үлдэгдэл 597.1 мянган төгрөгөөр, бараа материалын дансны үлдэгдэл 1,175.2 мянган төгрөгөөр тус тус өссөн нь аудитын залруулгатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 40,865.2 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 229.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд өр төлбөрийг барагдуулсантай байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 38,863.1 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 337,439.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 337,439.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 337,738.0 мянган төгрөгийн, санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 336,591.5 мянган төгрөгийг зарцуулж, 848.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Засгийн газраас усны үнийн хөнгөлөлтөд 7,713.2 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-аас 20,000.0 мянган төгрөгийн орон нутгийн төсвөөс 28,004.3 мянган төгрөгийн, нийт 55.717,5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг орлогыг бүрдүүлсэн.

Нэмэлт орлогоос 5,000.0 мянган төгрөгийг Отгонтэнгэр уулын тахилгын арга хэмжээнд, 20.000,0 мянган төгрөгийг Навчит ногоон ой ХХК-руу ойжуулалтын зардалд, 29.984,8 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулан, 732,7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Цалингийн зардлаас олгосон урамшуулал, нэмэгдэл цалин, тэтгэмж урамшууллыг буруу тооцоолон олгосон, хэмнэгдсэн зардлыг ХХОАТ-т шилжүүлэн авлагаар тайлагнасан, элэгдлээ нөхсөн ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг актлах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

ЗДТГ-ын дарга нь батлагдсан орон тооноос 1 орон тоо илүү ажиллуулснаар Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалтыг зөрчсөн байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цалингийн нэмэгдэл, урамшууллыг олгохдоо хууль, дүрэм журмыг биелүүлэн ажиллаж, удирдлагын зүгээс санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 70.575,2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 55.717,5 мянган төгрөгийн алдааг залруулж, 6.179,2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгч, 7.563,5 мянган төгрөгийн алдаанд албан шаардлага өгч, 1.115,0 мянган төгрөгийн алдаанд төлбөрийн акт тогтоолоо.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлан баталгаажуулах хугацаанд нэмэлт санхүүжилтийн тайланг ирүүлээгүй 55.717,5 мянган төгрөгийн алдаанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

1.1. Илрүүлэлт:

✓ Улс төрийн албан хаагчид 267,0 мянган төгрөгийн урамшуулал олгосон, Тамгын газрын даргад үр дүнгийн урамшууллыг 20 хувиар буюу 198,9 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон

✓ Хэмнэгдсэн зардлыг ХАОАТ-т шилжүүлж 649,068.00 төгрөгийн авлагаар тайлагнасан

1.2 Шийдвэрлэлт

✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 оны тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3, 4.2.3.8 дахь заалтуудыг үндэслэн

илүү тооцож олгосон цалин хөлс, илүү шилжүүлсэн авлагыг нөхөн төлүүлэхээр 1.115,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

1.1. Илрүүлэлт:

✓ Тамгын газрын болон, санхүүгийн албаны дарга нар Тагнуулын тусгай шалгалтад оролгүй нууц хариуцсаны 4,319,0 мянган төгрөгийн нэмэгдлийг олгосон,

✓ батлагдсан орон тооноос 1 орон тоо илүү ажиллан 3.244,4 мянган төгрөгийн цалингийн сангаас цалингийн зардлыг гаргасан

1.2 Шийдвэрлэлт

✓ Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 оны тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6, 4.2.1.11 дэх заалтуудыг үндэслэн Тагнуулын аюулгүй байдлын шалгалтад хамруулж, зөвшөөрөл ирсэн тохиолдолд нэмэгдлийг зохих журмын дагуу олгох, аймгийн ИТХ-аас батлагдсан орон тооны хязгаарт ажиллан, илүү ажиллаж байгаа 1 орон тоог ажлаас нь чөлөөлж шийдвэрлүүлэхээр 7.563,5 мянган төгрөгийн албан шаардлагыг хүргүүлсэн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ 1.650,0 мянган төгрөгийн үнэтэй 2020 онд худалдан авсан Си-Ти-Эс ХХК-ний нягтлан бодох бүртгэлийн болон нярвын программыг 2021 онд ашиглаагүй.
- ✓ Элэгдлээ бүрэн нөхсөн ашиглах боломжгүй 9 ш авто тээврийн хэрэгсэл байгааг дээд газартаа уламжлан шийдвэрлээгүй

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн болон нярвын программыг ашиглан хагас жилийн тайланг бэлтгэж гаргах
- ✓ Элэгдлээ бүрэн нөхсөн ашиглах боломжгүй 9 ш авто тээврийн хэрэгслийг дээд газартаа уламжлан актлуулах

2. Арвилан хэмнэлттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

- ✓ Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчид 6 сарын тэтгэмжийг хууль зөрчин олгосон

2.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Тэс сумын ЗДТГ	6	70.5	1	55.7	1	1.1	1	7.5	3	6.1